

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

(2024 оны бүтэн жилийн байдлаар)

2024 оны 12 дугаар сарын 24

Өлгий сум

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт		Хариуцах нэгж, албан тушаал	Хэрэгжилт	Хувь
		Хугацаа	Хүрэх үр дүн			
Нэг. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр						
1.1	Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах шаардлагатай албан тушаалтнуудын 2023 оны ХАСХОМ-ыг тогтоосон хугацаанд нь гаргах, тайлан мэдээг зохих журмын дагуу гаргаж АТГазарт хүргүүлэх.	02-р сарын 15	Авлигын эсрэг хуулийн 10, 11 дүгээр зүйл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23, 24 дүгээр зүйлийг хэрэгжүүлсэн байна.	Холбогдох албан хаагчид	Тус байгууллагад хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах үүрэг бүхий 3 албан тушаалтан байгаа ба бүгд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай 23 дугаар зүйлийн 23.3-т заасны дагуу ХАСХОМ-ийг хуульд заасан хугацаанд тайлагнасан болно.	100%
1.2	Сул орон тоо гарсан болон төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэлийг ил тод нээлттэй болгох	Жилдээ	Үйл ажиллагааны нээлттэй ил тод байдал бий болсон.	Өмчийн ашиглалт зохицуулалт хариуцсан мэргжилтэн Т.Эрболат	Монгол улсын Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 312 дугаар тогтоолоор Орон нутгийн өмчийн газраас худалдан авах ажиллагааны газрын чиг үүргийг салгаж, аймгийн Засаг даргын 2024 оны А/431	100%

					дугаар захирамжаар байгууллагын бүтэц орон тоог шинэчлэн батлуулсан. Батлагдсан бүтэц орон тооны хүрээнд Төрийн албаны холбогдох хууль тогтоомжийн дагуу сул орон тооны захиалгыг Төрийн албаны зөвлөлийн Баян-Өлгий аймагт дахь салбар зөвлөлд албан бичгээр хүргүүлж, сонгон шалгаруулалтыг ил тод зарлуулан сонгон шалгаруулалтаар сул орон тоог нөхөх ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулан ажилласан. Тайлант жилийн хугацаанд тус байгууллагад шилжин ирсэн 4 төрийн албан хаагч болон сонгон шалгаруулалтаар нэр дэвшүүлэн томилогдсон 2 албан хаагчийг Хүний нөөцийн цахим системд бүртгэж холбогдох бичиг баримтыг бүрдүүлж албажуулав.	
1.3	Төрийн захиргааны албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлуулна.	Жилдээ	Албан хаагчдын ажил чиг үүрэг тодорхой болсон байна.	Өмчийн ашиглалт зохицуулалт хариуцсан мэргжилтэн Т.Эрболат	Аймгийн Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 19 -ний өдрийн А/566 дугаар захирамжаар Орон нутгийн өмчийн газрын	100%

					даргын албан тушаалын тодорхойлолтыг, Орон нутгийн Өмчийн газрын даргын 2024 оны 07 дугаар сарын 19-нй өдрийн А/26 тоот тушаалаар байгууллагын Төрийн захиргааны албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг тус тус шинэчлэн баталсан.	
1.4	Нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх	Жилдээ	Гомдол мэдээлэл хугацаандаа шийдвэрлэгдэж, нээлттэй ил тод байдал бий болно.	Өмчийн ашиглалт зохицуулалт хариуцсан мэргжилтэн Т.Эрболат	Тайлант жилийн хугацаанд албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг бүртгэгдээгүй. Цахимаар болон утсаар гомдол мэдээлэл хүлээн авах боломжийг бүрдүүлэн холбоо барих 75704242 дугаартай утас болон https://umch.bo.gov.mn/ цахим хуудас ажиллуулж байна.	100%
1.5	Нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг зохих хууль журамд нийцүүлэн албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх	Жилдээ	Мэргэшсэн тогтвортой төрийн алба бий болно.	Өмчийн ашиглалт зохицуулалт хариуцсан мэргжилтэн Т.Эрболат	Тайлант хугацаанд 2 албан хаагчийн ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварыг харгалзан үзэж, хууль тогтоомжийн хүрээнд мерит зарчмын дагуу ахлах мэргэжилтнээр дэвшин томилогдов.	100%

Хоёр . Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, албан хаагчдыг АТГ-аас зохион байгуулах сургалтад хамруулах чиглэлээр						
2.1	АТГ-аас зохион байгуулдаг авлигын эсрэг анхан болон давтогч сургалтад албан хаагчдыг хамруулсан байх.	тухай бүр	Албан хаагчдын авлигын эсрэг мэдлэг дээшилж, авлигаас ангид болсон байна.	Өмчийн ашиглалт зохицуулалт хариуцсан мэргжилтэн Т.Эрболат	Авлигата тэмцэх газраас 2024 оны 12 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулсан Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилт, үр дүн, анхаарах асуудлын талаарх сургалтад байгууллагаас 3 албан хаагч хамрагдсан болно.	100%
2.2	Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн нөөц бололцоо, сургагч багшаар дамжуулан байгууллагын албан хаагчдад зохион байгуулах.	2024 оны 2 дүгээр улиралд	Албан хаагчид сургалтад хамрагдаж, тодорхой хэмжээний мэдээ, мэдээлэлтэй болсон байна.	Өмчийн ашиглалт зохицуулалт хариуцсан мэргжилтэн Т.Эрболат	Байгууллагын авлигын эсрэг төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Авлигаас урьдчилан богино хэмжээний видео танилцуулгыг байгууллагын албан хаагч нарт үзүүлж, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулан ажиллав.	70%
2.3	АТГ-аас бэлтгэсэн тв шторк, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, байгууллагын албан ёсны цахим хуудсаар иргэд, олон нийтэд хүргэсэн байх.	жилийн турш	Иргэд, олон нийтийн эрх зүйн мэдлэг нэмэгдсэн байна.	Хууль, хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудит хариуцсан мэргжилтэн Н.Ерлан	АТГ-аас бэлтгэсэн тв шторк, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага байгууллагын албан ёсны цахим хуудаст тогтмол байршуулан иргэд, олон нийтэд түгээж байна.	100%
Гурав: Төсөв, санхүү, зардлын ил тод байдал болон мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр						
3.1	Байгууллагын 2024 оны үйл ажиллагааны зардлын төсөв, 2023 онд санхүүгийн тайланд	2024 оны 1 дүгээр улиралд	Байгууллагын үйл ажиллагааны зардлын төсөв болон өмнөх оны санхүүгийн тайланд	Нягтлан бодогч Б.Журагат	2023 онд санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, тайлан, хөрөнгийн зардал, арга	100%

	хийсэн аудитын дүгнэлтийг цахим хуудсанд байршуулах		хийсэн аудитын дүгнэлт олон нийтэд ил тод болсон байна.		хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэлийг байгууллагын https://umch.bo.gov.mn/ цахим хуудсын "Шилэн төсөв" цэс дотор байршуулсан болно.	
3.2	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх, шилэн дансны цахим хуудсанд тайлан, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, орон тооны өөрчлөлт, аудитын дүгнэлт зэрэг шаардлагатай мэдээллүүдийг цаг тухайд нь байршуулах.	сар бүр	Хуулийн хэрэгжилт хангагдаж, байгууллагын санхүү, хөрөнгө оруулалтын талаарх мэдээлэл ил тод болсон байна.	Нягтлан бодогч Б.Журагат		100%
Дөрөв. Бусад						
4.1	Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх, хариуг хугацаанд нь мэдэгдэх.	тухай бүр	Авлигатай тэмцэх газраас ирсэн зөвлөмж, мөрдөгчийн мэдэгдэл, зерчил арилгуулах албан бичгийн хүрээнд холбогдох шийдвэрүүдийг биелүүлж хариу мэдэгдсэн байна.	Хууль, хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудит хариуцсан мэргэжилтэн Н.Ерлан	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг 2024 оны 11 дүгээр сарын байдлаар гаргаж хүргүүлсэн.	100%
4.2	Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга уриа, аянд нэгдэж ажиллах	тухай бүр	Байгууллагын зүгээс авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлсэн байна.	Хууль, хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудит хариуцсан мэргэжилтэн Н.Ерлан	Төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан Авлигын эсрэг санал, санаачилга уриа, аянд нэгдэж хамтран ажиллаж байна. Аяны хүрээнд хийгдсэх ажил, сурталчилгааны ажлыг дэмжин байгууллагын цахид хуудаст байршуулан ажиллаж байна.	100%

4.3	Авлигын эсрэг үйл ажиллагааны талаар байгууллагын ажилтнуудад зөвлөмж, арга зүйн туслалцаа үзүүлэх	тухай бүр	Авлигын эсрэг үйл ажиллагааны үр дүн дээшилсэн байна.	Хууль, хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудит хариуцсан мэргэжилтэн Н.Ерлан	АТГ-аас бэлтгэсэн тв шторк, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага байгууллагын албан ёсны цахим хуудаст тогтмол байршуулан, ажилан албан хаагч нарт үзүүлэн ажиллав.	100%
-----	--	-----------	---	--	--	------

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ДҮН

Орон нутгийн өмчийн газар нь авлигын эсрэг хууль тогтоомжоор хүлээсэн үүрэг, Авлигатай тэмцэх газраас өгсөн чиглэл, зааврын дагуу “байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөг боловсруулан баталж төлөвлөгөөннд 4 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх нийт 13 арга хэмжээг тусган хэрэгжилтийг ханган ажилласан. Байгууллагын Авлигын эсрэг үйл ажиллагааны 2024 оны бүтэн жилийн хэрэгжилтийн явцын дүнг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан үнэлгээний аргачлалын дагуу өөрийн үнэлгээг хийж дор танилцуулав:

- Төлөвлөсөн нийт 13 арга хэмжээ, үүнээс “Үр дүнтэй” буюу 100 хувь хэрэгжсэн 12
- “Тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70 хувьтай хэрэгжих шатанд байгаа арга хэмжээ – 1;
 - “Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 30 хувийн хэрэгжилт бүхий арга хэмжээ – 0;
 - “Үр дүнгүй” буюу 0 хувь, хэрэгжээгүй, тасарсан – 0;
 - “Үнэлэх боломжгүй” буюу өөрсдөөс хамаарахгүй болон хугацаа болоогүй байгаа арга хэмжээ – 0;
- Хэрэгжилтийн дундаж хувь, үнэлгээ – 97.6 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” үнэлгээ (өөрийн үнэлгээгээр)-

тэй байна.

ХЯНАСАН:

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА

Б.СЕРИК

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

ХУУЛЬ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Н.ЕРЛАН



Handwritten signature of N. Erlan.